# 6-р анги Уран зохиол Ч.Лодойдамба "Шаргачин" өгүүлэг

## 6.1д Зохиолын орчныг орон ба цагийн дүрслэлээр ялган таних

## Ээлжит хичээлийн ажлын хуудас

Ч.Лодойдамба

Шаргачин (өгүүллэгийн хэсгээс)

Хаврын хурц нар нэлээд дээр мандаад ойр орчмыг хөхөмдөг манан бүрхэж өргөн талд байгаа юмс цөм зэрэглэн жирвэлзэж байлаа. Цайдам хөндийн зүүн зах нь болсон хэсэг дэрс рүү эхээс гараад хэдхэн хоносон цайвар цагаан янзага дагуулсан шаргачин орж ирлээ.

Янзага нь тонгочин тоглож орчин тойронд өөрөөс нь өөр юмгүй мэт бүхнийг мартан явахад эх нь тал бүр сэрвэлзэн өчүүхэн чимээг ч сэрэмжлэн чагнаж нүдэнд нь торсон бүхнийг <<Юу вэ? Яах гэж байна?>> гэсэн бололтой нарийвчлан ажиглаж явлаа. Ураг нь дуусаагүй өөг сүүндээ гэдэс нь цадсанаас ч юмуу нялх бие нь тоглоомдоо ядарснаас ч юмуу, аль зуу зуун жилээр үргэлжилсэн хатуу амьдралын сургаал ч юм уу, бүү мэд. Юу ч гэсэн дэрсэнд орсны дараа янзага нь удалгүй нуугдан унтав.

Ер нь шаргачин өдрийн цагт нялх янзагаа бут бүюу дэрсэнд хяруулж нуугаад өөрөө шинэхэн ургасан ногоо чимхлэн иддэг. Энэ үед ямар нэгэн аюул ирвэл хурдан хөлийн хүчээр дагуулан зугтаж төөрүүлээд эргэж ирэхэд, унтаж хоцорсон үрдээ аюулыг зайлуулсан баярт уулзалтаар цэцэглэсэн амьдралаар амтлагдсан сүүрээ өгдөг...



LIVEWORKSHEETS

2. Хаана?, Хэзээ? гэсэн асуултад хариулагдах үгсийг зохиолын хэсгээс түүж бичээрэй.

**Хаана?**

**Хэзээ?**

1. Зохиолын эхлэл хэсгээс орчныг хэрхэн дүрсэлснийг зөв харгалзуулаарай.

Хаана болж байна вэ?

Хэзээ болж байна вэ?

Цаг агаар, байгаль дэлхий ямар байсан бэ?

Хаврын хурц нар, ойр орчныг хөхөмдөг манан бүрхэж өргөн талд байгаа юмс цэм зэрэглэн жирвэлзэнэ.

өргөн талд

хавар



LIVEWORKSHEETS

3. Зохиолын эхлэл ба төгсгөл хэсгийн орчны дүрслэлийг уншаад ямар мэдрэмж төрснөө өгөгдлөөс тохиромжтой хариулт бүрийг холбоорой.

гашуудам

амар амгалан

хөгжилтэй

баяртай

Зохиолын эхлэл хэсэг

Зохиолын төгсгөл хэсэг

жаргалтай

аймшигтай

өрөвдмөөр

харамсалтай



LIVEWORKSHEETS

4. Дараах зургийг ажиглаад эхлэл хэсэгт эх үр хоёрын жаргалтай байгааг зохиолч хэрхэн дүрсэлснийг олж, тайлбарлан бичээрэй.



LIVEWORKSHEETS

5. Анир чимээгүй тал, хар тас хоёрыг зохиолын төгсгөлд дүрсэлсний учир юу вэ?







LIVEWORKSHEETS